



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/265

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хэрлэн сумын Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг)-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Батсайхан), барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010449

05 Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 01 өдрийн А/265
дугаар захирамжийн хавсралт



Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2021 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
Орон нутгийн төсөв						
1	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын барилгын гадна фасадны засвар	2021	2021	50,000.0	50,000.0	Хэрлэн сумын Засаг дарга
	Нийт дүн			50,000.0	50,000.0	